

# Үр дүнтэй асуултын төрлийг тодорхойлох

Дараах асуултууд нь багш Даниел 1–3-ын талаар хичээл зааж байхдаа ашиглаж болох жишээ асуултууд юм. Асуулт бүр суралцагчдыг суралцах загвартай холбоотой хүссэн үр дүн рүү чиглүүлэн, туслах болно. Асуулт бүрийг уншаад, үүнийг суралцах загварын хүчин зүйлсийн алинд хэрэглэж болохыг тогтоо. Асуулт бүрийн хажуугийн зайд дараах тэмдэглэлүүдээс нэгийг бич. Үүнд:

- **ХСАО**- Хам сэдэв ба агуулгыг ойлгох
- **СЗОТ**- Сургаал, зарчмуудыг олж тогтоох
- **СЗО**- Сургаал, зарчмуудыг ойлгох
- **СЗҮАХМ**- Сургаал, зарчмуудын үнэн ба ач холбогдлыг мэдрэх
- **СЗХ**- Сургаал, зарчмуудыг хэрэгжүүлэх

- \_\_\_\_\_ 1. Даниел болон түүний нөхдийн адил итгэлээ ашигласнаар таны эсвэл бусдын амьдрал адислагдсан тухай туршлагаа сана. Үр дүнд нь ямар ямар адислал ирсэн бэ?
- \_\_\_\_\_ 2. Даниел болон түүний нөхдийн адил өнөөгийн өсвөр насныхан итгэлээ ашиглах хэрэгтэй нөхцөл байдлын ямар жишээ байна вэ?
- \_\_\_\_\_ 3. Даниел 3:25-д гардагчлан Шадрах, Мешах, Абед-него нарт аюул тулгарах мөчид Их Эзэн хаана байсан бэ?
- \_\_\_\_\_ 4. Бид энэ хэсгээс ямар зарчим тодорхойлж болох вэ?
- \_\_\_\_\_ 5. Тодорхойлсон зарчмын дагуу, хэрэв та хамгийн том аюул тохиолдсон үедээ Их Эзэний оршихуйд орохуйц зохистой байсан бол энэ нь таны амьдралд ямар өөрчлөлт авчрах байсан бэ?
- \_\_\_\_\_ 6. Даниел болон түүний нөхөд хааны зоогоос хүртэхээс татгалзсан нь ямар зарчмыг үзүүлж байна вэ (Даниел 1-ийг үзнэ үү)?
- \_\_\_\_\_ 7. Шадрах, Мешах, Абед-него нар “гал дундаас гарч ирж” байхад (Даниел 3:26) Небухаднезарын цэргийн “зоригт дайчид” яагаад үхсэн бэ (Даниел 3:20 ба 22-р шүлгийг үзнэ үү)?
- \_\_\_\_\_ 8. Бид Шадрах, Мешах, Абед-него нартай адил, яагаад дэлхийн сайн сайхан хэмээн тунхагласан зарим зүйлээс хүртэхийг татгалзах хэрэгтэй вэ?
- \_\_\_\_\_ 9. Шадрах, Мешах, Абед-него нарын еврей нэр нь хэн байсан бэ? (Даниел 1:7-г үзнэ үү.)
- \_\_\_\_\_ 10. Бурхан яагаад сайн хүмүүсийг хор хөнөөл эсвэл аюулаас үргэлж хамгаалдаггүй гэж та бодож байна вэ?
- \_\_\_\_\_ 11. Та Даниел ба түүний нөхдөөс сурсан зүйлсээ амьдралынхаа ямар хэсэгт хэрэгжүүлж болох вэ?

